



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/179

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжих Бор-Өндөр сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Г.Лхагвахатан	- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА